

МАНУТХГ-ын Хамгаалалтын 2019 оны 03 дугаар сарын 29-ны
өдрөөс 2019 оны 04 дүгээр сарын 05-ны хооронд хийж
хэрэгжүүлсэн ажлын тайлан

2019 оны 04 дүгээр
сарын 05-ны өдөр

Өлгий хот

1. Эх дэлхийн цаг 2019 арга хэмжээг "Хуванцар, гялгар уутнаас татгалзъя" уриан дор Дэлхийн байгаль хамгаалах сангийн Ирвэстэй нутгийн ирээдүй төслийн дэмжлэгээр Байгаль орчин, аялал жуулчлалын газар, ХИС-ийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургууль, Цагдаагийн газартай хамтран зохион байгууллав. Тухайн арга хэмжээний хүрээнд ЕБС-ийн дэргэдэх Эко клубын сурагчид, аймгийн Скаутын зөвлөлийн скаутууд, Уагдаагийн газрын дэргэдэх Өсвөрийн сэргийлэгид, Дугуйчдын холбооны дугуйчидтай хамтран нийт 300 гаруй сурагчдын парад хийв. Мөн аймгийн төв талбайд сурагчдын дунд марафон гүйлт, Аха тэмцээн явуулж, 9 хүүхдийг өргөмжлөл, Абай бичиг хэргийн дэлгүүрээс ном авах эрхийн бичгээр шагнав. Эко клубын сурагчдын санаачилгаар Өлгий сумын 8, Бугат, Толбо сумдын өрх толгойсон эхчүүдэд 50 ширхэг улайсдаг гэрлийг сүүн гэрлээр сольж өгөв. Цаашид аймгийн Цахилгаан сүлжээний газартай хамтран эрчим хүчний хэрэглээнд хяналт тавьж, үр дүнг сарын дараа танилцуулах болно. 20.00-21.00 цагийн хооронд болон зарим гол зам, гудамжын гэрэлтүүлгийг унтраан, лаатай үдэшийг зохион байгууллав.
2. Өлгий хотын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт улсын хөрөнгө оруулалтаар 2019 онд шинээр баригдаж буй цогцолбор сургууль, цэцэрлэгийн талбайд 2019 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр 10.00-12.00 цагийн хооронд "Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2019" нэгдсэн арга хэмжээний нээлтийн үйл ажиллагаанд тус Хамгаалалтын захиргааны мэргэжилтэн М.Жухан, С.Нурлан нар оролцов.
3. Ой, хээрийн түймэр гарах, бугын эвэр түүх зөрчлөөс урьдчилан сэргийлэх, загасны үржлийн үе эхэлж байгаатай холбогдуулан, хориглосон хугацаанд загас барих, агнуулахгүй байх талаар байгаль хамгаалагч нарт чиглэл хүргүүлж Алтай Таванбогдын БЦГазрын Даян, Ой харагай, Сумдайраг, Арал толгой, Онхад, Баянзүрх чиглэлд Хилийн 0165 дугаар ангийн 1,2 заставын ахлагч нартай хамтарч тогтомол эргүүл хяналтын ажлыг хийж гүйцэтгэв. Хяналт шалгалтын явцад Хар ямаат, Сонгинот чиглэлд бугын эвэр түүх зорилгоор зөвшөөрөлгүйгээр нэвтэрсэн 18 иргэнийг Монгол Улсын Хилийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.3 дугаар хэсэг, Зөрчлийн тухай хуулийн 16.1 дэх хэсгийг зөрчсөн үйлдлээр Хилийн 03 дугаар заставын бие

бүрэлдэхүүн, Даян, Ой харгай хэсгийг хариуцсан байгаль хамгаалагч нар Ш.Ахмет, Т.Марат нар хамтарч саатуулж, арга хэмжээ авав.

4. Мөн Даяннуур чиглэлд Аймгийн Цагдаагийн Газрын эрүүгийн тасагтай хамтарч хийсэн хяналт шалгалтын үеэр ОХУлсын 8 иргэн, Монгол Улсын 1 иргэнийг 16 ширхэг Монгол Хадран загасыг хууль бусаар агнасан гэмт хэргийн шинжтэй үйлдлийг илрүүлж, Монгол Улсын Эрүүгийн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг үндэслэн Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан үйлдлээр эрүүгийн хэрэг үүсэж, Аймгийн цагдаагийн газарт хэрэг бүртгэлийн ажиллагаа явагдаж байна.
5. Аймгийн Саян телевизээр Монгол Улсын Амьтны тухай хуулийн 9.2.8-д жил бүрийн дөрөвдүгээр сарын 1-нээс зургаадугаар сарын 15-ныг хүртэл загасыг үржлийн үед нь агнахыг хориглосоныг хэлж, загасанд үржлийн үед нь халдвал тухайн төрөл зүйл устах хүртэл аюултай тул үржлийн энэ хугацаанд загас агнахгүй байхыг иргэдэд анхааруулав. Мөн Энэхүү зөрчлийг Улсын тусгай хамгаалалттай газар нутагт үйлдсэн тохиолдолд Монгол улсын эрүүгийн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг болохыг ард иргэдэд мэдээлэл өгөв.

МАНУТХГ-ын Хамагаалалтын Захиргаа